



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 04 сарын 10 өдөр

Дугаар А/115

Сүхбаатар сум

Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг түр хугацаанд хориглох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 "а", "л" 30 дугаар зүйлийн 30.1.6, 39 дүгээр зүйлийн 39.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8, 32.1.12, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5, 14 дүгээр зүйлийн 14.3.1, 14.4, Чөлөөт бүсийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, аймгийн Онцгой комиссын 2020 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн 43 дугаар хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх, томуу, томуу төст өвчний өвчлөл, тархалтыг бууруулах зорилгоор 2020 оны 04 дүгээр сарын 11-ний өдрөөс 2020 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийг дуустал хугацаанд аймгийн нутаг дэвсгэрт архи, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг хориглосугай.

2. Энэ захирамжийн 1 дэх заалтыг хэрэгжүүлж, түр хориглосон хугацаанд аймгийн Засаг даргын 2020 оны А/16 дугаар захирамжийн 1.4 дэх заалтын үйлчлэлийг зогсоосугай.

3. Аймгийн Засаг даргын 2020 оны "Иргэдийн эрүүл мэндийн хамгааллыг сайжруулах, зарим үйл ажиллагааг түр хязгаарлах тухай" А/16 дугаар захирамжид нэмэлт өөрчлөлт оруулах тухай" А/57 дугаар захирамжийн 2 дахь дэд заалтын 1.9 дэх хэсгээс " ... нийтийн хоолны чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй цагийн хуваарийг өглөөний 10.00 цагаас оройны 20.0 цаг хүртэл" гэсэн заалтыг "өглөөний 10.00 цагаас оройны 22.00 цаг хүртэл" гэж өөрчилж, сунгасугай.

4. Энэхүү хориглосон хугацаанд архи, согтууруулах ундаа худалдаалахгүй байх талаар Алтанбулаг чөлөөт бүсийн Захирагчийн албатай хамтран, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг аймгийн Онцгой байдлын газрын дарга, хурандаа /Г.Баатар/, аймгийн Цагдаагийн газрын дарга, хурандаа /А.Энхбат/ нарт даалгасугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Цагдаагийн газрын дарга, хурандаа /А.Энхбат/, аймгийн Онцгой байдлыг газрын дарга, хурандаа /Г.Баатар/,

аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга /Ж.Отгонхүү/, сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  Ш.ОРГИЛ